



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 743

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16 нэрийн, нийт 290,759,900.00 (хоёр зуун ерэн сая долоон зуун тавин есөн мянга есөн зуу) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 33,576,000.00 (гучин гурван сая таван зуун далан зургаан мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга Б.Эрдэнэваанчигт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 2-д өдрийн
14.42 дугаар тогтоолын хавсралт

СПОРТЫН АНАГААХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ҮНДЭХ ӨРТӨГТҮЙ,
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д		Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1.Машин тоног төхөөрөмж									
1		Проектор / View sonic 3 DLP /	2021-01-04	1	528,000.00	528,000.00	192,000.00	192,000.00	2
2		Зүрх судас амьсгалын системийг хянах аппарат / AT- 104 /	2021-01-04	1	32,590,000.00	32,590,000.00	1,200,000.00	1,200,000.00	1
3		Эмнэлгийн шкаф	2021-01-04	2	103,150.00	206,300.00	60,000.00	120,000.00	1
4		Эмнэлгийн багажны шүүгээ	2021-01-04	3	51,533.33	154,600.00	24,000.00	72,000.00	1
5		Зөөвөрийн массажны ор 2018 / BLT 1100-1 /	2017-12-01	5	1,600,000.00	8,000,000.00	480,000.00	2,400,000.00	2
6		Зөөвөрийн спирометр 2018 / Contec SP10 /	2017-12-01	2	2,000,000.00	4,000,000.00	600,000.00	1,200,000.00	2
7		Лазер Эмчилгээний аппарат / Skanlab Laser Pro /	2017-12-01	1	15,500,000.00	15,500,000.00	1,200,000.00	1,200,000.00	1
8		Лактат хэмжигч 2018 / Lactate scout /	2017-12-01	3	3,200,000.00	9,600,000.00	600,000.00	1,800,000.00	2
9		Сэргээн засах эмчилгээний аппарат / Solaris 709 plus /	2017-12-01	1	28,000,000.00	28,000,000.00	5,640,000.00	5,640,000.00	2

10	Физик эмчилгээний цогц аппарат / BTL - 5818 LM /	2017-12-01	3	43,000,000.00	129,000,000.00	4,320,000.00	12,960,000.00	2
11	Хүйтэн эмчилгээний	2017-12-01	1	41,500,000.00	41,500,000.00	4,272,000.00	4,272,000.00	2
12	Лактат / Анализатор / суурин	2021-01-04	1	20,240,000.00	20,240,000.00	2,040,000.00	2,040,000.00	1
Дүн			24	188,312,683.33	289,318,900.00	20,628,000.00	33,096,000.00	
2.Тавилга аж ахуйн эд хогшил								
13	Ширээ трапец цайвар шар	2021-01-04	1	49,000.00	49,000.00	120,000.00	120,000.00	2
14	Хөлдөөгч	2021-01-04	1	40,000.00	40,000.00	60,000.00	60,000.00	1
15	Хөргөгч 95л	2021-01-04	1	32,000.00	32,000.00	60,000.00	60,000.00	2
Дүн			3	121,000.00	121,000.00	240,000.00	240,000.00	
3.Бусад үндсэн хөрөнгө								
16	Гүйлтийн зам / Diamond - 61 /	2021-01-04	1	1,320,000.00	1,320,000.00	240,000.00	240,000.00	2
Дүн			1	1,320,000.00	1,320,000.00	240,000.00	240,000.00	
НИЙТ ДҮН			28	189,753,683.33	290,759,900.00	21,108,000.00	33,576,000.00	
					(хоёр зуун ерэн сая долоон зуун тавин есөн мөнгө есөн зуун)	(хорин нэгэн сая нэг зуун найман мянган) 11	(гучин гурван сая тавин зуун далан зургаан мянган)	